- Тус төвийн дотоод аудитор нь тайлант онд ажлын төлөвлөгөө батлуулж ажилласан боловч зарим хийсэн ажил нь тодорхойгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар гүйцэтгэсэн ажил нь аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 4,383,704.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 65,755.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 49,316.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 683,469.4 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 954,619.2 | 1,348,851.8 | 394,232.6 |
| Үндсэн хөрөнгө | 4,626,297.5 | 4,915,534.4 | 289,236.9 |
| Нийт хөрөнгө | 5,580,916.7 | 6,264,386.2 | 683,469.5 |
| Хуримтлагдсан үр дүн | 1,580,087.6 | 2,290,773.0 | 710,685.4 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 5,580,916.8 | 6,264,386.2 | 683,469.4 |

Дансны үлдэгдэлд дараах материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Бараа материалын дансны үлдэгдэл 1,348,851.2 мянган төгрөг болж өмнөх оноос 394,232.6 мянган төгрөгөөр өссөн нь Ковидтой холбоотойгоор “Арга хэмжээ авч ажиллах тухай” Эрүүл мэндийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 2/3389 тоот, 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 1А/1700 тоот албан бичгээр /3-5 сарын нөөцийн бүрдүүлэлттэй байхаар/ өгсөн чиглэлийн дагуу эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад бараа материалын 1,692,181.9 мянган төгрөгийн худалдан авалт хийж, хандиваар 2,943,158.3 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авч нэмэгдүүлснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,915,534.4 мянган төгрөг болж урд оноос 289,236.9 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд төсвийн хөрөнгөөр 96,376.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 28,030.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан, хандиваар 685,002.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой байна.

Тайлангаар Нийслэлийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 14-ны А/654 тоот захирамж, Өмчийн ашиглалт удирдлагын газрын 2020 оны 05 дугаар сарын 22–ны 2/1079

тоот шийдвэрийн дагуу 70,416.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг Нийслэлийн түргэн тусламжийн газарт балансаас баланс руу шилжүүлж данс бүртгэлээс хассан байна.

*Хүснэгт 2.* Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Үйл ажиллагааны орлого | 6,830,200.6 | 8,783,421.9 | 1,953,221.3 |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 2,821,535.1 | 3,743,164.7 | 921,629.6 |
| Тусламж санхүүжилтийн орлого | 4,008,665.6 | 5,040,257.2 | 1,031,591.6 |
| Цалин хөлс нэмэгдэл урамшуулал | 1,995,292.7 | 2,150,505.3 | 155,212.6 |
| Нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 265,320.9 | 316,791.8 | 51,470.9 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 152,300.4 | 330,474.3 | 178,173.9 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 1,931,051.4 | 2,693,457.9 | 41,240.1 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 39,739.2 | 37,629.8 | -2,109.4 |
| Үйл ажиллагааны зардал | 4,383,704.6 | 5,528,859.1 | 1,145,154.5 |
| Үйл ажиллагааны бус зардал | 1,302,414.8 | 2,571,093.4 | 1,268,678.6 |
| Үр дүн | 1,144,081.2 | 683,469.4 | -460,611.9 |

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,953,221.3 мянган төгрөг буюу 28.6 хувиар өссөн нь үнэ төлбөргүй авсан бараа материал болон үндсэн хөрөнгө, ковидтой холбоотой Эрүүл мэндийн яамнаас хуваарилж өгсөн нэг удаагийн буцалтгүй тусламж, туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн зэргээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 1,145,154.5 мянган төгрөгөөр буюу 26.1 хувиар өссөн байна. Зардлыг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад ковидтой холбоотой цалин, цалингийн нэмэгдлүүд, нийгмийн даатгалын шимтгэл, тогтмол зардал, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, бараа үйлчилгээний бусад зардлууд өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,153,976.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 2,285,928.5 мянган төгрөгөөр, татаас ба урсгал шилжүүлгийг 2,868,048.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Эрүүл мэндийн яамнаас хуваарилсан төсвийн дагуу нийт зардлыг 5,153,976.7 мянган төгрөгт багтаан зарцуулахаар, ажиллагсдын тоог 103 орон тоотой байхаар баталж, хуваарь хийж ирүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн 5 хөтөлбөрийн 47 арга хэмжээний хэрэгжилтийг санхүүжүүлэхээр 5,153,976.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,742,127.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,999,969.6 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан, 284,694.7 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор, 127,000.0 мянган төгрөгийг үндсэн бус үйл ажиллагааны орлогоор тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,717,963.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, 2,010,366.8 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан, 274,113.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого, 115,004.2 мянган төгрөгийг үндсэн бус үйл ажиллагааны орлого, нийт 5,117,631.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 4,740,009.5 мянган төгрөгийг, урсгал шилжүүлэгт 377,622.1 мянган төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 37,629.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 36,160.6 мянган төгрөг буюу 0.7 хувиар хэмнэгдсэн байна. Тухайлбал, үндсэн цалин 34,418.7 мянган, нийгмийн даатгалын шимтгэл 2,089.3 мянган, нормативт зардал 8,415.0 мянган төгрөгөөр хэмнэсэн үндсэн шалтгаан нь орон тоо дутуу буюу хавсран ажиллуулан зохих хувиар цалинг олгож байсан мөн төсвийг бодитой бус төлөвлөсөн зэргээс шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан хөрөнгө 2,010,366.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 274,113.0 мянган төгрөг, ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгөөс 184.5 мянган төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлжээ.

Үүнээс цалин нийгмийн даатгалын зардалд 631,026.6 мянган, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 354,545.0 мянган, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 1,001,472.0 мянган, бичиг хэрэг, тээвэр шатахуунд 20,268.7 мянган, хөдөлмөр хамгаалал, урсгал засварт 13,000.0 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 261,510.2 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь Монгол Улсын Их Хурлын 1999 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Төрийн өмчөөс нийслэлийн өмчид шилжүүлэх тухай” 23 дугаар тогтоолоор нийслэлийн өмчит байгууллага гэж тодорхойлогдсон, үйл ажиллагаа нь Эрүүл мэндийн яаманд харьяалагддаг онцлогтой байгууллага байна.

Тус төв нь 5 алба нэгжийн нян, тархвар судлагч эмч, амьтан, шимэгч судлагч, лаборант, ариутгагч, бусад мэргэжилтнүүдийн үйл ажиллагаанд тулгуурлан үндсэн гол үйл ажиллагаа нь явагддаг.

Тайлант онд зоонозын халдварыг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ судалгаа, нотолгоонд тулгуурлан зохион байгуулж, эрсдэлийг бууруулах үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажилласан бөгөөд санхүүжилтийн гүйцэтгэл нь дараах байдалтай байна. Үүнд:

1. Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн шуурхай хариу арга хэмжээний чадавхыг сайжруулах зорилтын ажлын хүрээнд Зоонозын шалтгаант үйл явдал, тохиолдол, дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед нотолгоонд суурилсан хариу арга хэмжээг оновчтой, шуурхай зохион байгуулах ажлыг төсвийн санхүүжилтээс 650,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэл нь 25 хувь буюу 708,241.8 мянган төгрөгийн зарцуулалт хийгдсэн, зөрүүг Эрүүл мэндийн яамнаас зөвшөөрөл авч нэмэлт санхүүжилтийн данснаас санхүүжүүлсэн байна. Мөн тарваган тахал өвчний тандалтад улсын төсвөөс 28,329.7 мянган төгрөг, хачигаар дамждаг өвчний судалгаа хийхэд 8,498.9 мянган төгрөг, шувууны томуу өвчнийг илрүүлэхэд 8,498.9 мянган төгрөгийн зарцуулалтыг тус тус хийсэн байна.

2. Лавлагаа шатлалын түвшинд болон анхан шатны онош зүйн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах ажил тэр дундаа хүн амын дунд коронавируст халдвар /COVID-19/-ыг илрүүлэх лабораторид суурилсан тандалт судалгаа хийхэд улсын төсвөөс 446,200.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээс 786,200.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж батлагдсан төсвийн 3 хувь буюу 84,989.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээс 80 хувь буюу 1,827,731.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.
3. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил өргөжиж олон улсын түвшинд хүргэх улсын төсвөөс 30,000.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж, 0.15 хувь буюу 4,249.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.
4. Мэргэшсэн хүний нөөц, нэгдсэн удирдлага бүхий тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд тэр дундаа эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд батлагдсан төсвийн 70 хувь буюу 1,983,077.1 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээс 20 хувь буюу 456,932.9 мянган төгрөгийн тус тус зарцуулалт хийгджээ.
5. Байгууллагын засаглал, санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулах ажил үндсэн ажлын хүрээнд хийгджээ.

### 3.8 Аудитын гол асуудал

Төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан нэмэлт санхүүжилтийн орлогын зарцуулалтын талаарх шийдвэр нь тодорхойгүй, хууль дүрэм журамд заасантай бүрэн нийцэхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2021 онд 5,000.0 мянган төгрөгөөс дээш нийт 7,292,172.6 мянган төгрөгийн 108 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,006,649.9 мянган төгрөгийн 26 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцох

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 355,100.0 мянган төгрөгийн 6 алдаа зөрчилд зөвлөмж өгч зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой 350,100.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 5,000.0 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байдалтай байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим хуудсанд 17 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд өгсөн 1 албан шаардлагын биелэлт 70 хувь, 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт-4* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 13,085.2 | - | - | 1 | 13,085.2 | 70.0 |
| Зөвлөмж | 2 | - | 2 | - | - | - | 100.0 |
| Нийт дүн | 3 | 13,085.2 | 2 | - | 1 | 13,085.2 | 90.0 |

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх” талаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй зөрчлийг давтан гаргасан, нягтлан бодох бүртгэлийн программыг сайжруулах, илүү цагийг зөв тооцоолох талаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн нэмэлт санхүүжилт, Эрүүл мэндийн даатгалын сангаас авч байгаа мөнгөн орлого, хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн орлого, тэдгээрийн зарцуулалт, худалдан авалт, эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо, захирлын тушаал шийдвэр, Төрийн болон орон нутгийн тухай хуулийн нийцлийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 463,022.1 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 350,100.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 112,922.1 мянган төгрөгийн 5 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Анхан шатны баримтай холбоотой асуудал***

*1. Илрүүлэлт:*

Бэлэн мөнгөний орлогын баримт /НХ Маягт МХ-1/ -ыг хөтлөөгүй 12,000.0 мянган төгрөгийн гүйлгээг данс бүртгэлд тусгасан, 88,095.3 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн шаардах хуудас дутуу бичсэн, 9,657.0 мянган төгрөгийн хоол хүнсний материалыг орлогын дансанд бүртгээгүй, шууд зардал руу бичилт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д “Аж нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл үйлчилгээний шат дамжлага,аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан Маягт заавар батлах тухай заавар журамтай нийцээгүй, тохиолдсон, нийцсэн бөгөөд зохистой, үнэн зөв байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

*2. Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын тушаалаар баталсан заавар журмын дагуу бэлэн мөнгөний орлогын баримт /НХМаягт МХ-1/ хөтөлж данс бүртгэлд тусгах.

***2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

*1. Илрүүлэлт:*

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой эдийн засгийн үр өгөөж хүртэж буй дансны үлдэх өртөг нь тэг болсон 767 нэр төрлийн тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, тоног төхөөрөмжид дахин үнэлгээ хийгдээгүй байна. Энэ нь Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулийн 5.1.5 “хэмжигдэхүйц байх”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дугаар тушаалын 7.1 “... элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй

боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж, шийдвэрлүүлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх, үнэлгээ хуваарилалт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

*2. Өгсөн зөвлөмж:*

Дээрх үндсэн хөрөнгийг цаашид УСНББОУС-т заасны дагуу санхүүгийн жил бүрийн эцэст хөрөнгийн үнэ цэнэ, эдийн засгийн үр өгөөж хүртэж буй эсэхийг үнэлэн, үнэлгээнд үндэслэн актлах хөрөнгө болон дахин үнэлүүлэх шаардлагатай хөрөнгийн жагсаалтыг ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлэх

### 3. Цалингийн зардалтай холбоотой асуудал

*1. Илрүүлэлт:*

Тайлант онд нэр бүхий ажилтанд ур чадварын нэмэгдэл болон үр дүнгийн урамшуулал олгохдоо хийсэн ажлыг шалгуур үзүүлэлтээр нь дүгнэж дээд шатны байгууллагаас албан ёсны шийдвэр гараагүй байхад 2,130.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, 1,039.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал, нийт 3,169.8 мянган төгрөгийг олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3, 4 заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 1.2.2 –д Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид , 3.12-д Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж шийдвэр гаргана гэсэн заалттай нийцээгүй, тохиолдсон, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

*2. Өгсөн зөвлөмж:*

Засгийн газрын тогтоолын дагуу байгууллагын захирлын ур чадварын нэмэгдэл болон үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохдоо шалгуур үзүүлэлтийн дагуу ажлаа дүгнүүлж дээд байгууллагаас урамшуулал олгох шийдвэр гарсан хойно олгох.

### 4. Санхүүгийн дотоод хяналттай холбоотой асуудал

*1. Илрүүлэлт:*

Тус төвийн дотоод аудитын ажилтны хийсэн санхүүгийн хяналтын ажил, түүний үр дүн нь тодорхой харагдахгүй, өгсөн зөвлөмж, албан шаардлага нь баримтаар нотлогдоогүй.

Шатахууныг нормоор тооцож олгодог, олгосон дүнгээр зарцуулалтыг бичдэг үүнтэй холбоотой 2000 орчим бичилтийг журналд бичсэн, нягтлан бодох бүртгэлийн хэмнэлттэй байх зарчмыг хэрэгжүүлээгүй. Бараа материалын няравын дэлгэрэнгүй бүртгэлийг журмын дагуу бүрэн хөтөлж баталгаажуулаагүй байна.
Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтлах 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 20 дугаар зүйлийн 20.2. Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

*2. Өгсөн зөвлөмж:*
Жолоочтой тооцоо хийх дансыг шинээр нээх, шатахууны тооцооны хуудасны зарцуулалтын дүнгээр журналд бичилтийг хийх, бараа материалыг зарлага болгосон баримтыг журмын дагуу бүрдүүлэх, санхүүгийн ажилтнууд дотоод хяналтын ажлаа сайжруулах

### *5. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал*

*1. <u>Илрүүлэлт:</u>*

Төсвийн төлөвлөгөө гүйцэтгэлд хийсэн эдийн засгийн шинжилгээгээр өмнөх онтой харьцуулсан төсвийн гүйцэтгэлийн дүн их хэмжээгээр өссөн. Төсвийн төсөөлөл, гүйцэтгэл нь их хэмжээний зөрүүтэй, тухайлбал: цалин хөлс төлөвлөгөөгөөр 2,565.288.8 мянган төгрөг, гүйцэтгэл 2,150,505.3 мянган төгрөг, эм бэлдмэл төлөвлөгөө 843,258.3 мянган төгрөг гүйцэтгэл 1,517,706.6 мянган төгрөг мөн ковидтой холбоотойгоор төлөвлөгдөөгүй зардлууд их хэмжээгээр гарсан. Энэ нь зардал өсөхөд нөлөөлсөн байна. Төсвийн тухай хуулийн 5.1.2-д төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 6.2.2-д жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх, 6.4.1-д төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулах, 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 27.1.2-д макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ тооцоонд үндэслэсэн байх гэсэн шаардлагатай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Төсвийг төлөвлөхдөө гүйцэтгэх ажил, төсөл хөтөлбөр тус бүр дээр хүний нөөц, хэрэглэгдэх бараа, ажил үйлчилгээ, бусад зардлыг алба, нэгж хэсгүүдээс саналыг авах, гүйцэтгэлд эдийн засгийн шинжилгээ хийж түүний үндсэн дээр бодитоор төлөвлөх, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулга | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | дүн | Тоо | дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар | | | | | | | | | | | | |
| 1 | ЗӨСҮТ | АХГ-2022 /366/ НА-СТА-ТШЗ | Бараа материалын бүртгэл дээр 88,095.3 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн шаардах хуудас дутуу бичсэн, 9,657.0 мянган төгрөгийн хоол хүнсний материалыг орлого болгоогүй шууд зардал болгосон, Бэлэн мөнгөний орлогын баримт /НХ Маягт МХ-1/ -ыг хөтлөөгүй 12,000.0 мянган төгрөгийн гүйлгээг данс бүртгэлд тусгасан | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын тушаалаар баталсан заавар журмын дагуу Анхан шатны баримтыг бүрэн хөтөлж данс бүртгэлд тусгах | 1 | 109,752.3 | | | | | 1 | 109,752.3 |
| 2 | ЗӨСҮТ | АХГ-2022 /366/ НА-СТА-ТШЗ | Элэгдлээрээ өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой эдийн засгийн үр өгөөж хүртэж буй 1,978,357.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй 767 нэр төрлийн тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, тоног төхөөрөмжид дахин үнэлгээ хийгдээгүй | Дээрх үндсэн хөрөнгийг цаашид УСНББОУС-т заасны дагуу санхүүгийн жил бүрийн эцэст хөрөнгийн үнэ цэнэ, эдийн засгийн үр өгөөж хүртэж буй эсэхийг үнэлэн, үнэлгээнд үндэслэн актлах хөрөнгө болон дахин үнэлүүлэх шаардлагатай хөрөнгийн жагсаалтыг ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлэх | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| 3 | ЗӨСҮТ | АХГ-2022 | Тайлант онд нэр бүхий ажилтанд ур чадварын нэмэгдэл болон үр дүнгийн | Засгийн газрын тогтоолын дагуу | 1 | 3,169.8 | | | | | 1 | 3,169.8 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | /366/ НА-СТА-ТШЗ | урамшуулал олгохдоо хийсэн ажлыг шалгуур үзүүлэлтээр нь дүгнэж дээд шатны байгууллагаас албан ёсны шийдвэр гараагүй байхад 2,130.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, 1,039.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал бүгд 3,169.8 мянган төгрөгийг олгосон | байгууллагын захирлын ур чадварын нэмэгдэл болон үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохдоо шалгуур үзүүлэлтийн дагуу ажлаа дүгнүүлж дээд байгууллагаас урамшуулал олгох шийдвэр гарсан хойно олгож байх | | | | | | | | |
| 4 | ЗӨСҮТ | АХГ-2022 /366/ НА-СТА-ТШЗ | Шатахууныг нормоор тооцож олгодог, олгосон дүнгээр зарцуулалтыг бичдэг үүнтэй холбоотой 2000 орчим бичилтийг журналд бичсэн, нягтлан бодох бүртгэлийн хэмнэлттэй байх зарчмыг хэрэгжүүлээгүй. бараа материалын нярвын дэлгэрэнгүй бүртгэлийг журмын дагуу бүрэн хөтөлж баталгаажуулаагүй, нягтлан бодогчид бараа материалын бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй | Жолоочтой тооцоо хийх дансыг шинээр нээх, шатахууны тооцооны хуудасны зарцуулалтын дүнгээр журналд бичилтийг хийх, бараа материалыг зарлага болгосон баримтыг журмын дагуу бүрдүүлэх, санхүүгийн ажилтнууд дотоод хяналтын ажлаа сайжруулах | 1 | - | | | | | 1 | - |
| 5 | ЗӨСҮТ | АХГ-2022 /366/ НА-СТА-ТШЗ | Завсрын аудитаар бараа үнэ төлбөргүй ирсэн бараа материалын баримт дутуу бүрдсэн | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын тушаалаар баталсан заавар журмын дагуу Анхан шатны баримтыг бүрэн хөтөлж данс бүртгэлд тусгах | 1 | 350,100.0 | | 350,100.0 | | | | |
| Дүн | | | | | 5 | 463022.1 | 1 | 350,100.0 | | | 4 | 112,922.1 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | | |
| 1 | ЗӨСҮТ | АХГ-2022/366/НА-СТА-ТШЗ | Төсвийн төлөвлөгөө гүйцэтгэлд хийсэн эдийн засгийн шинжилгээгээр урд онтой харьцуулсан төсвийн гүйцэтгэлийн дүн их хэмжээгээр өссөн нь төсвийг төлөвлөхдөө бодит бусаар төлөвлөсөн /төсвийн төсөөлөл, гүйцэтгэл зөрүүтэй, тухайлбал : цалин хөлс төлөвлөгөөгөөр 2,565.288.8 мянган төгрөг, гүйцэтгэл 2,150,505.3 мянган төгрөг, эм бэлдмэл төлөвлөгөө 843,258.3 мянган төгрөг гүйцэтгэл 1517.706.6 мянган төгрөг/ мөн ковидтой холбоотойгоор төлөвлөгдөөгүй зардлууд их хэмжээгээр гарсан | Төсвийг төлөвлөхдөө гүйцэтгэх ажил, төсөл хөтөлбөр тус бүр дээр хүний нөөц, хэрэглэгдэх бараа, ажил үйлчилгээ, бусад зардлыг алба, нэгж хэсгүүдээс саналыг авах, гүйцэтгэлд эдийн засгийн шинжилгээ хийж түүний үндсэн дээр бодитоор төлөвлөх, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах | 1 | - | | | 1 | | | - |
| 2 | ЗӨСҮТ | АХГ-2022/366/НА-СТА-ТШЗ | Шилэн дансны цахим хуудсанд Эдийн засагч нь нийт 1,006,549.9 мянган төгрөгийн 26 гүйлгээг 8,10,11 дүгээр саруудад мэдээлээгүй, хугацаа хоцроож мэдээлсэн | Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох | 1 | | | | 1 | | | |
| Дүн | | | | | 2 | - | | | 1 | - | 1 | - |
| Нийт дүн | | | | | 7 | 463,022.1 | 1 | 350,100 | 1 | | 5 | 112,922.1 |

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 230/А0150054 Улаанбаатар хот
АХГ-2022/1366/НА-СТА-ТШЗ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, мөн тайлант онд 108 мэдээлэл байршуулахаас 1,006,549,921 төгрөгийн 26 мэдээлэл хоцроож зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 "*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ*", 6.4.5 "*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга,хүлээн авагчийн нэр*", 6.4.7 "байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "*Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын 4.2.2 "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн холбогдох албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-нийөдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал Н.Цогбадрахад даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Г.ГҮНЖИДМАА
БОДЬТУСГАЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ З.МЯГМАРСҮРЭН

9006109
9019